



БАРУУН БҮСИЙН
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН



MONGOLIAN ACADEMY
OF SCIENCES

Говь-Алтай аймгийн бодлогын баримт бичигт хийсэн шинжилгээний үр дүн

“Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдлыг бууруулахад орон нутгийн иргэд, захиргааны байгууллагуудыг шинжлэх ухааны мэдээлэлд тулгуурлан бодлого боловсруулах аргазүйд сурган чадавхжуулах нь” төсөл

Х.Номинболор
Стратеги судалгааны хүрээлэн
Ахлах шинжээч

Говь-Алтай аймаг
2023.03.29

Судалгааны хүрээ

СУРГАЛТ

Экологийн эмзэг байдлын үнэлгээ

- Уур амьсгалын өөрчлөлтийн илэрхийлэгч үзүүлэлтүүд
- Газрын доройтол
- Хөрсний элэгдэл
- Цөлжилт
- Бэлчээр ашиглалтын индекс
- Газар ашиглалтад гарч буй өөрчлөлт
- Усны нөөцийн хомсдол
- Малын тоо толгой, хорогдол

Зайнаас тандан, ГМС, экологийн болон ландшафтын шинжилгээний загваруудыг ашиглан сонгосон бүс нутагт нэгдсэн шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох



СУРГАЛТ

Бодлогын баримт бичгийн шинжилгээ

- Аймаг, сумын хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг
- Байгаль орчны хамгааллын төлөвлөгөө
- Аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө
- Бүсийн хөгжлийн төлөвлөгөө
- Үндэсний түвшний тогтвортой хөгжлийн зорилтууд

ТХЗ-д суурилсан хөгжлийн бодлогын шаардлагад нийцүүлэх



СУРГАЛТ

Бодлого боловсруулалт, хэрэгжүүлэлт

- Бодлогын үндсэн баримт бичгүүд
- Орон нутгийн хотын бодлого төлөвлөлөлт
- Хэрэгжүүлэх стратеги

Бодлого боловсруулалтад орон нутгийн иргэдийн оролцоог хангах, сургалт, сурталчилгаа явуулах

Бэлчээрийн эмзэг байдлын үнэлгээ

Exposure

Дарамт нөлөө
үзүүлэгч

Нөхцөлдүүлэгч хүчин зүйл

- Ган
- Хуурайшил
- Малын тоо

Шинж чанар

- Давтамж
- Хүчин чадал
- Хугацаа
- Хамрах цар хүрээ

Sensitivity

Өртөгч хүчин зүйл

Нийгэм-эдийн засгийн нөхцөл

- Хүн ам
- Шилжилт хөдөлгөөн
- Малчин өрхийн тоо
- Эрэгтэйчүүдийн дундаж нас
- Нэг хүнд ногдох хадгаламжийн хэмжээ
- Нэг хүнд ногдох төмс, хүнсний ногооны хэмжээ

Байгаль орчны нөхцөл

- Ургамлан бүрхүүл
- Газрын доройтол
- Усны хомсдол
- Малын хорогдол
- Малын хээл хаялт
- Нэг малд ногдох хадлан тэжээл

Resilience

Даван туулах чадавх

Coping/ response

**Хариу арга хэмжээ –
Давж гарах**

- Тохирсон хөтөлбөр
- Үйл ажиллагаа
- Бодлого хэрэгжүүлэх

Impact/ response

**Хариу арга хэмжээ -
Нөлөөлөх**

- Нөлөөлөл нь амьдралын чанар
- Эдийн засгийн бүтээмж
- Экосистемийн үйлчилгээнд нөлөөлөхөд түүнийг бууруулах

Adjustment & adaptation/ response

**Хариу арга хэмжээ – Дасан зохицох,
тохируулах**

- Цоо шинэ үйл ажиллагаа, бодлого, хөтөлбөр эхлүүлэх

Хөгжлийн бодлогын баримт бичгүүд, шинжилгээ хийх хэрэгцээ шаардлага

1. НҮБ-ийн Ерөнхий Ассамблейн 70-р чуулган (2015-9-25)-аар Тогтвортой хөгжлийн зорилтуудыг дэвшүүлж, Тогтвортой хөгжил-2030” хөтөлбөрийг баталсан.
2. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-ыг УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан. /УИХ-ын 2020.05.13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор хүчингүй болсон/
3. Монгол Улсын ногоон хөгжлийн бодлого 2014-2030. /УИХ-ын 2021.11.12-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор хүчингүй болсон/
4. Төрөөс баримтлах бодлогууд (уур амьсгалын өөрчлөлт, хөдөө аж ахуй г.м)
5. Хөгжлийн бодлого, стратеги, төлөвлөгөөнүүдийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль (2020)-д нийцүүлэн, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг тусган шинэчлэх
6. Алсын хараа- 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
7. Шинэ сэргэлтийн бодлого - Монгол Улсын хөгжлийн дунд хугацааны бодлого

Дэлхий нийтийн тогтвортой хөгжил 2030 хөтөлбөр



1. Ядуурлыг устгах
2. Өлсгөлөнг зогсоох
3. Эрүүл мэндийг дэмжих
4. Чанартай боловсролыг дэмжих
5. Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах
6. Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах
7. Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх
8. Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох
9. Инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх
10. Тэгш бус байдлыг бууруулах
11. Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих
12. Хариуцлагатай хэрэглээг дэмжих
13. Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах
14. Далай, тэнгисийн нөөцийг хамгаалах
15. Хуурай газрын эко системийг хамгаалах
16. Энх тайван, шударга ёсыг цогцлоох
17. Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх

Дээрх 17 зорилгыг
хангах

169 зорилт

169 зорилтыг үнэлэх
229 хүртэлх шалгуур
үзүүлэлтэй

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030




- 2016 оны 02-р сарын 05
- УИХ-ын 19 дүгээр тогтоолоор баталсан.
- 4 бүлэг 44 зорилт
- 20 шалгуур үзүүлэлт

1-р үе шат 2016-2020 он
2-р үе шат 2021-2025 он
3-р үе шат 2026-2030 он



Монгол Улсын НОГООН хөгжлийн бодлогын зарчим



1. Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлнэ.

2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.

3. Ногоон эдийн засгийг дэмжих санхүүжилт, татвар, зээл, урамшууллын оновчтой хөшүүргийг нэвтрүүлж, байгаль хамгаалал, хүний хөгжил, цэвэр технологийг дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

4. Ногоон ажил эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулан ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.

Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа төлөвлөгөө 6 зорилт

6. Уур амьсгалын өөрчлөлт, бүс нутгийн байгалийн нөөц баялаг, сэргэх чадавхад нийцүүлэн хүн амын суурьшлыг төлөвлөн хөгжүүлнэ.

5. Байгальд зохицсон ахуй соёлын үнэт зүйлсийг хөгжүүлж, боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновацийг ногоон хөгжлийн хурдасгуур болгоно.

ТХЗ-д суурилсан орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих багц шалгуур үзүүлэлтүүд

БАГЦ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ТХЗ
ДАСАН ЗОХИЦОХ (ADAPTATION)		
<i>Нийгмийн дасан зохицох, сэргэн хөгжих чадавх</i>	Амьжиргааны олон талт эх үүсвэрийг бий болгож, ядуурлыг бууруулах	ТХЗ 1
	Эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тогтолцоог бий болгох, иргэдийн эрүүл мэндийг дэмжих	ТХЗ 3
	Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангах, ариун цэврийн байгууламж нэмэгдүүлж, усны зохистой хэрэглээг дэмжих	ТХЗ 6
	Зохистой хөдөлмөр эрхлэлт, ажлын байр бий болгох	ТХЗ 8
	Байгалийн болон соёлын нөөцөд суурилсан байгальд ээлтэй, тогтвортой аялал жуулчлал	ТХЗ 8
<i>Байгалийн сэргэн хөгжих чадавх</i>	Бэлчээрийн зохистой менежмент, бэлчээрийн экосистемийн хамгаалал	ТХЗ 15
	Ойн тогтвортой менежмент	ТХЗ 15
	Цөлжилт, газрын доройтлыг сааруулах	ТХЗ 15
	Биологийн олон янз байдлын хамгаалал	ТХЗ 15
	Тусгай хамгаалалттай газар нутгийн тогтвортой менежмент, хамгаалал	ТХЗ 15
СААРУУЛАХ (MITIGATION)		
	Эрчим хүчний хэрэгцээг тогтвортой, найдвартай эх үүсвэрээр бүрэн хангах	ТХЗ 7
ӨӨРЧЛӨЛТ БИЙ БОЛГОХ ЧАДАВХ (TRANSFORMING CAPACITY)		
	Хүртээмжтэй, чанартай боловсрол, чадавх	ТХЗ 4
	Дэд бүтэц, зам тээврийн сүлжээг сайжруулах замаар зах зээл, үйлчилгээнд ойртох	ТХЗ 9
	Хүн, байгалийн уламжлалт өв, соёлыг хадгалах	ТХЗ 11
	Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, байгалийн гамшиг, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадавх	ТХЗ 13

Бодлогын баримт бичгүүд багц шалгууруудтай нийцэх нийцлийг үнэлэх онооны шалгуур

Нийцлийн түвшин	Нийцлийн тодорхойлолт	Оноо
Бүрэн нийцэл	Бодлого нь дасан зохицох, сааруулах, өөрчлөлт бий болгох чадавх (ДЗ/С/ӨЧ) гэсэн 3 багцын хүрээний шалгуур үзүүлэлтүүдтэй маш сайн нийцэлтэй байна. Бодлого нь тухайн багцад анхаарал хандуулж, тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэхээр багтаасан байна.	3
Хэсэгчилсэн нийцэл	Бодлого нь ДЗ/С/ӨЧ-ын үзүүлэлтүүдийг дэмжиж байгаа ч тухайн багц болон шалгуур үзүүлэлтүүдэд хэрхэн хүрэх нь тодорхой бус, бүрхэг байна. Тодорхой багц, шалгуур үзүүлэлтүүдэд бодитоор хүрэх талаар баримт нотолгоо хязгаарлагдмал.	2
Хязгаарлагдмал нийцэл	Бодлого нь ДЗ/С/ӨЧ-ийн тухайн шалгуур үзүүлэлтийг дэмжиж байгаа ч нийцэж байгааг нь батлах нотолгоо хомс байна.	1
Огт нийцэхгүй	Бодлого нь багц шалгууруудын хэрэгжилтийг дэмжиж байгааг илэрхийлэх баримт нотолгоо байхгүй.	0

Шинжилгээ хийсэн баримт бичгүүд

Бодлогын хамрах хүрээ	Баримт бичиг
Хөгжлийн бодлого	<ul style="list-style-type: none"><li data-bbox="787 525 2244 572">• Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлого 2008 – 2020<li data-bbox="787 622 2142 733">• Говь-Алтай аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 2016 – 2020
Хүрээлэн буй орчин	<ul style="list-style-type: none"><li data-bbox="787 819 2283 929">• Говь-Алтай аймгийн бэлчээрийн менежментийн хөтөлбөр 2012-2023<li data-bbox="787 975 2283 1085">• Говь-Алтай аймгийн цөлжилтийг сааруулах дэд хөтөлбөр 2012 – 2020<li data-bbox="787 1130 2015 1186">• Байгаль орчны мастер төлөвлөгөө 2012 – 2020

Бодлогын баримт бичгийн шинжилгээ

Бодлогын үндсэн зорилго, алсын хараа	Бодлогын зорилтууд: уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах чиглэлээр	Бодлогын зорилтууд: мал аж ахуй, бэлчээрийн чиглэлээр	ТХЗ, үндэсний хөгжлийн зорилтуудтай нийцэл	Гол оролцогчид	Санхүүгийн эх үүсвэр
--------------------------------------	---	---	--	----------------	----------------------

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГО 2008-2021

<p>Хүний хөгжилд тулгуурлан эдийн засгийг эрчимтэй хөгжүүлж хүн амын амьдралын түвшинг тууштай дээшлүүлэн, Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, тэтгэдэг, бүтэцтэй, суурилсан эдийн засагтай, цэцэглэн хөгжиж буй аймаг болоход оршино</p>	<p>Байгаль орчны бодлого дахь Стратегийн зорилт 6-д Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, цөлжилтийг сааруулах, сөрөг үр дагаврыг бууруулах чадавхийг бүрдүүлэх хүрээнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, байгалийн гамшгийн үед хүний нөөц, байгууллагын болон техникийн чадавхийг бүрдүүлнэ 2. Элсний нүүдлийг зогсоохын тулд орон нутгийн уур амьсгал, байгаль орчинд тохирсон мод тарина 3. Бэлчээрийн доройтлоос сэргийлнэ 4. Сул хөрсийг ургамалжуулах гадаад орнуудын туршлагыг судалж, нэвтрүүлэх 5. Цөлжилттэй тэмцэхэд нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ 	<p>Мал аж ахуйн салбарын бодлогын зорилтууд:</p> <ul style="list-style-type: none"> - Мал сүргийн бүтцийг зохистой хэмжээнд байлгах - Нутгийн болон өндөр ашиг шимт үүлдрийн мал сүргийн эзлэх хувийг нэмэгдүүлэх - Бигэр, Чандмань, Дэлгэр, Цогт, Шарга сумдын хадлангийн талбайг түшиглэн эрчимжсэн фермийн загвар аж ахуйг байгуулж, цаашид бусад сумдад хөгжүүлэх - Бэлчээрийн байдал, усан хангамжийн хүрэлцээний судалгаанд үндэслэн бэлчээрийг зохистой ашиглуулах - Ашиглалтгүй бэлчээрт худаг, уст цэг гаргах, усан сан, хөв байгуулах замаар бэлчээр ашиглалтыг нэмэгдүүлэх - Худаг ус гаргаж, бэлчээр ашиглалтыг сайжруулсан иргэд, малчдыг урамшуулах 	<p>Ерөнхий агуулгаар 2015 оноос хойш батлагдсан ТХЗ-ууд, болон үндэсний бодлого стратегид тусгагдсан боловч илүү нарийн уялдуулах шаардлагатай</p>	<p>Аймаг, сум, багийн засаг дарга нарыг оролцуулан удирдлагууд</p>	-
--	---	---	--	--	---

Бодлогын баримт бичгийн шинжилгээ

Бодлогын үндсэн зорилго, алсын хараа	Бодлогын зорилтууд: уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах чиглэлээр	Бодлогын зорилтууд: мал аж ахуй, бэлчээрийн чиглэлээр	ТХЗ, үндэсний хөгжлийн зорилтуудтай нийцэл	Гол оролцогчид	Санхүүгийн эх үүсвэр
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР, 2016-2020					
<p>Засгийн газрын хөтөлбөрүүдтэй уялдуулсан аймгийн 4 жилийн хугацаатай нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр</p>	<p>Энэ чиглэлээр тухайлсан зорилт байхгүй.</p> <p>Байгаль орчин, аялал жуулчлалын бодлогод цөлжилтийн үр дагаврыг бууруулж, байгаль орчны бохирдол доройтлыг хязгаарлан хүний амьдрах орчны чанарыг сайжруулах хүрээнд:</p> <p>Цөлжилт хүчтэй илэрсэн сумдыг сонгож, цөлжилттэй тэмцэх загвар сум бий болгоно</p> <p>Ойн санг нэмэгдүүлэн, нөхөн сэргээж ногоон байгууламжийг 2-3 дахин нэмэгдүүлнэ</p> <p>Усны нөөцийн хуримтлалыг бий болгож, булаг шандын усны эхийг хамгаална</p>	<ul style="list-style-type: none"> - Бэлчээрийн доройтлоос хамгаалах арга хэмжээ авна - Бэлчээрийн төлөв байдлыг судалж, бэлчээр зохион байгуулалтыг боловсронгуй болгоно - Аймгийн тэжээлийн аюулгүйн нөөцийг нөхөн бүрдүүлэх, хадгалах замаар мал аж ахуйг эрсдэлээс хамгаална 	<p>ТХЗ 13</p> <p>ТХЗ 15</p>	<p>Аймаг, сум, багийн засаг дарга нарыг оролцуулан удирдлагууд</p>	<p>Улсын болон аймаг, орон нутгийн төсөв</p> <p>Олон улсын санхүүжилт</p> <p>Орон нутгийн хөгжлийн сан</p>

Бодлогын баримт бичгийн шинжилгээ

Бодлогын үндсэн зорилго, алсын хараа	Бодлогын зорилтууд: уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах чиглэлээр	Бодлогын зорилтууд: мал аж ахуй, бэлчээрийн чиглэлээр	ТХЗ, үндэсний хөгжлийн зорилтуудтай нийцэл	Гол оролцогчид	Санхүүгийн эх үүсвэр
БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТИЙН ХӨТӨЛБӨР 2012-2023					
Бэлчээрийн зохистой ашиглалт, менежментийг хийж урт хугацааны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, хамгаалах, мал сүргийг чанартай бэлчээрийн тэжээлээр хангах	Тодорхой зорилго дэвшүүлээгүй	<ul style="list-style-type: none"> - Бэлчээрийг зүй зохистой ашиглах, хамгаалах орон нутгийн бодлого, эдийн засаг, бүтэц, менежментийн ээлтэй орчныг бүрдүүлнэ - Төлөвлөлт, шийдвэр гаргахад бэлчээрийн мэдээллийн системийг зөв ашиглах - Малчдын хамтын нийгэмлэгт тулгуурлан бэлчээрийг тогтвортой ашиглах шилдэг туршлагыг бий болгож, түгээнэ - Гадаргын усны ашиглалт, бэлчээрийн усалгааг сайжруулна - Малын гаралтай түүхий эдийг боловсруулах, борлуулах сүлжээг бий болгоно 	ТХЗ 15	Аймгийн Засаг даргын орлогч, аймаг, харъяа төрийн мэргэжлийн байгууллагуу даар ахлуулсан бэлчээрийн менежментий г хэрэгжүүлэх алба	Улсын болон аймаг, орон нутгийн төсөв Олон улсын санхүүжилт Орон нутгийн хөгжлийн сан

Бодлогын баримт бичгийн шинжилгээ

Бодлогын зорилго, үндсэн алсын хараа	Бодлогын зорилтууд: уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах чиглэлээр	Бодлогын зорилтууд: мал аж ахуй, бэлчээрийн чиглэлээр	ТХЗ, үндэсний хөгжлийн зорилтуудтай нийцэл	Гол оролцогчид	Санхүүгийн эх үүсвэр
--------------------------------------	---	---	--	----------------	----------------------

ЦӨЛЖИЛТТЭЙ ТЭМЦЭХ ДЭД ХӨТӨЛБӨР 2012-2020

Аймаг, орон нутгийн түвшинд тэмцэх	<ul style="list-style-type: none"> - Аймаг, орон нутгийн цөлжилтийн байдлыг үнэлж, холбогдох судалгааг өргөжүүлнэ - Цөлжилттэй тэмцэхэд шаардагдах зардлыг тооцож, үйл ажиллагааг эрчимжүүлж, хөрөнгө оруулалтыг цаашид нэмэгдүүлнэ - Байгаль орчинд ээлтэй технологи, техникийг орон нутагт нэвтрүүлнэ - Цөлжилттэй тэмцэхэд олон нийтийн оролцоо, мэдээллийн цар хүрээг нэмэгдүүлнэ 	<ul style="list-style-type: none"> - Бэлчээр ашиглалтын тогтолцоог боловсронгуй болгоно - Малчдын бүлэгт түшиглэн бэлчээр ашиглалтын үр ашгийг дээшлүүлнэ 	ТХЗ 13	Орон нутгийн засаг захиргаа, мэргэжлийн байгууллагуу Д	Жил бүрийн улсын болон орон нутгийн төсөв Олон улсын төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилт Дотоод, гадаадын иргэдийн хандив, хөрөнгө оруулалт
------------------------------------	---	---	--------	--	---

Бодлогын баримт бичгийн шинжилгээ

Бодлогын зорилго, алсын хараа	үндсэн зорилтууд: уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах чиглэлээр	Бодлогын зорилтууд: мал аж ахуй, бэлчээрийн чиглэлээр	ТХЗ, үндэсний хөгжлийн зорилтуудтай нийцэл	Гол оролцогчид	Санхүүгийн эх үүсвэр
-------------------------------	---	---	--	----------------	----------------------

БАЙГАЛЬ ОРЧНЫ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ 2012-2020

Байгаль орчны бодлогын шинэчлэлийн хүрээнд өнөөгийн байгаль орчны асуудлыг шийдвэрлэх	- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, цөлжилтийн нөлөөг бууруулах	- Бэлчээрийн тогтвортой, зохистой ашиглалт, хамгаалал	ТХЗ 13 ТХЗ 15	Орон нутгийн засаг захиргаа, мэргэжлийн байгууллагууд	Жил бүрийн улсын болон орон нутгийн төсөв Олон улсын төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилт Дотоод, гадаадын иргэдийн хандив, хөрөнгө оруулалт
---	--	---	------------------	---	---

Говь-Алтай аймгийн бодлогын баримт бичгүүдийн ТХЗ-д суурилсан багц шалгууруудтай нийцлийн ҮНЭЛГЭЭ

Бодлогын баримт бичиг	ТХЗ-д суурилсан уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хөгжлийн багц шалгуур				
	Дасан зохицох (Нийгмийн сэргэн хөгжих чадавх) (ТХ31, ТХ33, ТХ36, ТХ38)	Дасан зохицох (Байгалийн сэргэн хөгжих чадавх) (ТХ315)	Сааруулах (ТХ37)	Өөрчлөлт бий болгох чадавх (ТХ3 4, ТХ3 9, ТХ3 11, ТХ3 13)	Ерөнхий нийцэл
<i>Хөгжлийн бодлого</i>					
Аймгийн хөгжлийн цогц бодлого	2	2	1	1	(1.75) хязгаарлагдмал
Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	2	2	0	1	(1.25) хязгаарлагдмал
<i>Байгаль орчны бодлого</i>					
Байгаль орчны мастер төлөвлөгөө	1	3	0	2	(1.50) хязгаарлагдмал
Бэлчээрийн менежментийн хөтөлбөр	0	2	0	2	(1.33) хязгаарлагдмал
Цөлжилтийг сааруулах дэд хөтөлбөр	0	2	1	1	(1.33) хязгаарлагдмал

Бодлогын баримт бичгийн шинжилгээний дүн

Хөгжлийн цогц бодлого (ХЦБ)

Дасан зохицох- Нийгмийн сэргэн хөгжих чадавх:

- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эрүүл мэндийн суурь үйлчилгээг чанартай хүргэх чадавхийг бэхжүүлэх
- Усны нөөцийг бохирдуулах, хомсдохоос урьдчилан сэргийлэх, зохистой хэрэглээг хангах, ард иргэдийг эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангах
- Эко аялал жуулчлал, олон нийтэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгох

Дасан зохицох- Байгалийн сэргэн хөгжих чадавх:

- Малын бүтэц, үүлдэр угсааг сайжруулах,
- Алслагдсан болон усны хомсдолтой бэлчээрийг улирлын чанартай сэлгэн ажиллуулах замаар бэлчээрийн ашиглалтыг сайжруулах, усаар хангах арга хэмжээ
- Ойн сан бүхий газрын экологийн тогтвортой байдлыг хамгаалах, нөхөн сэргээх, цөлжилттэй тэмцэх, элсний нүүдлийг зогсооход тохиромжтой мод тарих, монгол элсний араар ногоон бүс байгуулах, цөлжилтийг сааруулахад сайн дурынхныг татан оролцуулах
- Байгаль орчныг хамгаалахад уламжлалт мэдлэг, арга барилыг ашиглах

Сааруулах:

- Сэргээгдэх эрчим хүчийг өргөнөөр ашиглах, хөдөөгийн малчин өрхүүдийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр бүрэн хангах, нүүрснээс утаагүй түлш үйлдвэрлэх жижиг үйлдвэрүүдийг байгуулах

Бодлогын баримт бичгийн шинжилгээний дүн

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр (АЗДҮАХ)

Дасан зохицох- Нийгмийн сэргэн хөгжих чадавх:

- Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, сум, өрхийн эмнэлгүүдийг эрүүл мэндийн суурь үйлчилгээг чанартай хүргэх чадавхийг бэхжүүлэх арга хэмжээ
- 400-аас доошгүй ажлын байр бий болгохоор тусгасан боловч хэрхэн хүрэх талаар нарийвчилсан заалт байхгүй.
- Усан сан, цөөрөм байгуулах, булаг шанд хамгаалах арга хэмжээ
- Мод тарих, ногоон байгууламж бий болгох замаар ногоон ажлын байр бий болгох

Дасан зохицох- Байгалийн сэргэн хөгжих чадавх:

- Бэлчээрийн доройтлоос урьдчилан сэргийлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах, тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг сайжруулах арга хэмжээ

Сааруулах:

- Тодорхой арга хэмжээ тусгаагүй

Өөрчлөлтийг бий болгох чадавх:

- Мал сүргийг эрсдэлээс хамгаалах, ойн нөөцийг нэмэгдүүлэх, говийн гайхамшигт 6 амьтныг хамгаалах менежментийг сайжруулах, улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх

Бодлогын баримт бичгийн шинжилгээний дүн

Байгаль орчны мастер төлөвлөгөө

Дасан зохицох- Нийгмийн сэргэн хөгжих чадавх:

- Байгальд ээлтэй эко аялал жуулчлалыг хөгжүүлэх, орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, бодитой арга хэмжээ, хөрөнгө оруулалтыг дэмжих
- Нийгмийн сэргэн хөгжих чадахыг бэхжүүлэх чиглэлд дасан зохицох арга хэмжээ байхгүй

Дасан зохицох- Байгалийн сэргэн хөгжих чадавх:

- Цөлжилтийн нөлөөллийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг сааруулах, дасан зохицох арга хэмжээ
- Болзошгүй байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ
- Бэлчээрийн даацад тохируулан газар, бэлчээрийг тогтвортой ашиглах, хамгаалах, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, усны тогтвортой менежментийг хангах

Сааруулах:

- Тодорхой арга хэмжээ тусгаагүй

Өөрчлөлтийг бий болгох чадавх:

- Байгаль орчны бодлого, шийдвэрийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх мэдээллийн системийг сайжруулах,
- Байгаль орчны тулгамдаж буй асуудлаар нэгдсэн ойлголтыг бий болгох, экологийн боловсрол олгох, тогтмол хэлэлцүүлэг, сургалт, семинар зохион байгуулах
- Байгаль орчинд хандах зөв хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн олон нийтийн сурталчилгааны кампанит ажил

Бодлогын баримт бичгийн шинжилгээний дүн

Бэлчээрийн менежментийн хөтөлбөр

Дасан зохицох- Нийгмийн сэргэн хөгжих чадавх:

- Нийгмийн сэргэн хөгжих чадахыг бэхжүүлэх чиглэлд дасан зохицох арга хэмжээ байхгүй

Дасан зохицох- Байгалийн сэргэн хөгжих чадавх:

- Олон нийтэд нээлттэй, малчдыг чадавхижуулахад чиглэсэн бэлчээрийн мэдээллийн системийг бий болгох
- Бэлчээрийг зохистой ашиглах, сайжруулах, хамгаалах, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, алслагдсан бэлчээрийг усжуулах бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх

Сааруулах:

- Тодорхой арга хэмжээ тусгаагүй

Өөрчлөлтийг бий болгох чадавх:

- Малын үүлдэр угсааг хамгаалах, байгалийн гамшгаас хамгаалах
- Орон нутагт малын гаралтай түүхий эд бэлтгэл, зах зээлийн зохистой сүлжээг бий болгох замаар бэлчээрийн даацаас хэтэрсэн малын тоог бууруулах
- Сумын болон сум дундын отрын бүсийг байгалийн нөөц газрын ангилалд оруулж, мал сүргийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх

Бодлогын баримт бичгийн шинжилгээний ДҮН

Цөлжилттэй тэмцэх дэд хөтөлбөр

Дасан зохицох- Нийгмийн даван туулах чадавх:

- Нийгмийн даван туулах, сэргэн хөгжих чадахыг бэхжүүлэх чиглэлд дасан зохицох арга хэмжээ байхгүй

Дасан зохицох- Байгалийн даван туулах чадавх:

- Малчдын бүлгийн туслалцаатайгаар бэлчээр ашиглалтыг сайжруулах
- Ойжуулалт, усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах
- Цөлжилттэй тэмцэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх

Сааруулах:

- Сэргээгдэх эрчим хүчийг дэмжинэ гэж байгаа ч авах арга хэмжээ хангалтгүй

Өөрчлөлтийг бий болгох чадавх:

- Цөлжилт, түүний үр дагаврыг иргэд, залуучуудад таниулах, боловсрол олгох
- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн талаар дурдаагүй.
- Хүүхэд, залуучуудад цөлжилт, байгаль экологийн доройтол, үр дагавар, хүчин зүйлийн талаар мэдлэг олгох, цөлжилттэй тэмцэх уламжлалт мэдлэг, дэвшилтэт технологийг түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх

Дүгнэлт

- Бодлогын баримт бичигт хийсэн шинжилгээгээр Говь-Алтай аймгийн бодлогын баримт бичгүүд нь ТХЗ-д суурилсан багц үзүүлэлтүүдтэй ерөнхийдөө “хязгаарлагдмал уялдаатай” байна.
- Хөгжлийн бодлогын баримт бичгүүд нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох багц үзүүлэлттэй тодорхой хэмжээнд нийцэж байгаа боловч нийгмийн дасан зохицох чадавхыг бэхжүүлэх арга хэмжээ хангалтгүй байна. Мөн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, өөрчлөлтийг бий болгох чадавх бүрдүүлэх чиглэлд хангалтгүй байна.
- Байгаль орчны бодлогын баримт бичгүүд нь уур амьсгалын өөрчлөлтөд байгалийн даван туулах чадавхыг нэмэгдүүлэх замаар дасан зохицох багц үзүүлэлттэй сайн нийцэж байгаа боловч нийгмийн дасан зохицох чадавхыг бүрдүүлэх арга хэмжээнүүд маш хангалтгүй байна. Энэ нь иргэд ирээдүйн өөрчлөлтөд сайн бэлтгэгдээгүй, уур амьсгал, хүрээлэн буй орчны сөрөг нөлөөллийг даван туулах чадвар бага хэвээр байгааг харуулж байна.

Дүгнэлт

- Говь-Алтай аймгийн хөгжлийн болон байгаль орчны бодлогод уур амьсгалын өөрчлөлтийг хөгжилд аюул учруулагч болохыг хүлээн зөвшөөрч, ялангуяа мал аж ахуйн салбарт уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг арилгах, түүнээс үүдэлтэй байгаль орчны доройтлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг санал болгож байгаа нь бодлогын баримт бичгүүдэд хийсэн дүн шинжилгээнээс харагдаж байна.
- 2012 онд батлагдсан Говь-Алтай аймгийн дунд хугацааны хөгжлийн бодлого буюу хөгжлийн цогц бодлого (ХЦБ)-ыг даян дэлхийн ТХЗ-ууд болон үндэсний түвшний бодлогууд (Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого)-д нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.
- Уур амьсгалын болон байгаль, нийгмийн бусад өөрчлөлтөд эмзэг байдлыг бууруулах, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг урагшлуулахад дасан зохицох арга хэмжээ чухал бөгөөд уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжлийг сайтар уялдуулсан бодлого шаардлагатай байгааг дүн шинжилгээ харуулж байна.

Өмнө хийсэн ижил төстэй ажлууд


ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ХӨХМОРЬТ СУМЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

- ❖ Сумын хөгжлийн бодлого, мастер төлөвлөгөө 2009-2021
- ❖ Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр

ЗАВХАН АЙМГИЙН ДӨРВӨЛЖИН СУМЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

- ❖ Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө
- ❖ Сумын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл

Тогтвортой хөгжлийн шалгуур үзүүлэлтээр сумын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд шинжилгээ хийх аргачлал




Эх сурвалж: Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн судлаачдын боловсруулсан ногоон хөгжлийн шалгуур үзүүлэлтэд тулгуурлав.

Хөхморьт сумын хөгжлийн бодлого, мастер төлөвлөгөөнд хийсэн шинжилгээний дүн

SOC06: Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг төлөвшүүлэх, эдийн засгийн байдлыг бэхжүүлэх арга хэмжээ

ECON02: Малын гаралтай түүхий эдийг боловсруулах жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, зах зээлд нийлүүлэхийг дэмжсэн арга хэмжээ

ENV02: Бэлчээрийг даацад тохируулан сэлгэн, хуваарьтай ашиглах арга хэмжээ
ENV06: Газрын доройтол, цөлжилтийг сааруулах арга хэмжээ



Дөрвөлжин сумын хөгжлийн бодлого, ТӨЛӨВЛӨГӨӨНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

SOC01: Ядуурлыг бууруулах, хүн амын орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээ


SOC03: Тогтвортой хөгжил, ногоон хөгжил, экологийн боловсролыг дэмжих, зөв дадал хэвшлийг бий болгоход чиглэсэн арга хэмжээ

SOC04: хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангах, инженерийн шугам сүлжээг сайжруулах, ариун цэврийн байгууламж нэмэгдүүлж, усны зохистой хэрэглээг бий болгоход чиглэсэн арга хэмжээ

ENV01: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, байгалийн гамшиг, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадавхийг бэхжүүлэх арга хэмжээ

ENV03: Усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлэх, усны эхийн болон эргийн экосистемийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ

ENV05: Газрын доройтол, цөлжилтийг сааруулах арга хэмжээ



ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1:

Байгалийн нөөцийн үр ашигтай, хэмнэлттэй технологийг дэмжин, хөдөө аж ахуйг түшиглэсэн жижиг үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлж, орлогыг тэгш хүртээмжтэй өсгөх замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгоно.

Зорилт 1: Малын эрүүл, таваарлаг, ашиг шимт байдалд анхаарч тоо толгойг бэлчээрийн даацад тохируулан бууруулж малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг стандартын дагуу бэлтгэн, зах зээлд нийлүүлэх тогтолцоог цогцоор бий болгон малчдын бодит орлогыг нэмэгдүүлнэ.(11)

Зорилт 2: Байгалийн нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай технологиор иргэдийн оролцоонд тулгуурлан ашиглаж жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. (8)

Зорилт 3: Сумын төсвийн төлөвлөлт, ил тод байдал, хяналтын тогтолцоог сайжруулан, төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлнэ. (4)

Зорилт 4: Банк санхүү, бизнесийн орчны таатай нөхцлийг бүрдүүлэх замаар ирээдүйн тогтвортой эдийн засгийн үндсийг бэхжүүлнэ.(6)

БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3:

Байгалийн нөөцийн тогтвортой байдлыг хадгалж, эрсдлийг даван туулах чадавхийг нэмэгдүүлэн, бэлчээрийн даацыг тохируулах замаар газрын доройтол, цөлжилтийг бууруулан биологийн олон янз байдал, байгалийн унаган төрхийг хамгаална.

Зорилт 1: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхийг сайжруулж, бэлчээрийн даацад тохируулан мал аж ахуй эрхэлж газрын доройтол, цөлжилтийг бууруулна. (11)

Зорилт 2: Уул уурхайн ашиглалт, олборлолтод хяналт, мониторингийн системийг сайжруулах замаар байгаль орчны мэдээллийн санг бүрдүүлнэ. (7)

Зорилт 3: Байгалийн нөөц, экосистемийн ашиглалт, хамгаалалт, хөгжлийн бүтээн байгуулалтад ногоон технологийг нэвтрүүлнэ. (9)

Зорилт 4: Биологийн олон янз байдал, байгалийн унаган төрхийг хамгаалах замаар аялал жуулчлалын брэнд бий болгоно. (11)

Анхаарал хандуулсанд баярлалаа

Эмзэг
байдал

Дасан
зохицохуй

Сэргэн
хөгжихүй

АЛСЫН ХАРАА 2050

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого



Үндэсний нэгдмэл
үнэт зүйл



Хүний
хөгжил



Амьдралын чанар ба
дундаж давхарга



Эдийн
засаг



Сайн
засаглал



Ногоон
хөгжил



Амар тайван
аюулгүй нийгэм



Бүсчилсэн
хөгжил



Улаанбаатар ба
дагуул хот

Нэг. Үндэсний нэгдмэл үнэт зүйл

Хоёр. Хүний хөгжил

Боловсрол

Эрүүл мэнд

Гэр бүл

Шинжлэх ухаан, инновац

Хүнд ээлтэй амьдрах орчин

Хөдөлмөрийн зах зээл

Монгол хүний удмын сан

Гурав. Амьдралын чанар ба дундаж давхарга

Нийгмийн хамгаалал, даатгалын тогтолцооны шинэчлэл

Хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнес

Дундаж давхарга

Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг

Газрын харилцаа

Дөрөв. Эдийн засаг

Чинээлэг Монгол

Ухаалаг санхүүгийн зах зээл

Бүс нутгийн хамтын ажиллагаа

Өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн

Үндэсний баялгийн сан

Тав. Засаглал

Ухаалаг засаглал

Ухаалаг бүтэц

Цахим Монгол

Чадварлаг ёсзүйтэй төрийн алба

Хүний эрхийг дээдэлсэн нийгэм

Авлигагүй засаглал

Зургаа. Ногоон хөгжил

Долоо. Амар тайван аюулгүй нийгэм

Зэвсэгт хүчин

Дархан хил

Хүн, нийгмийн амар тайван байдал

Хууль сахиулах салбар

Мэдээллийн аюулгүй байдал

Найм. Бүс, орон нутгийн хөгжил

Дэд бүтэц

Аялал жуулчлал

Тогтвортой хөдөө аж ахуй

Ес. Улаанбаатар ба дагуул хот

АЛСЫН ХАРАА 2050

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

АЛСЫН ХАРАА 2050

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого

Эх байгаль анхдагч

экосистем

Зорилт 6.1. Байгалийн үнэ цэн, өгөөжийг үнэлэн хамгаалж, анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.



Үнэт баялаг ус

Зорилт 6.3. Усны нөөцийн хомсдолоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулан, эрэлт хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ.



Зургаа. Ногоон хөгжил




Байгалийн баялгийн үр өгөөж

Зорилт 6.2. Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж хомсдолыг бууруулан, ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлнэ.

Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил

Зорилт 6.4. Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулна.



Мал аж ахуйн салбарын дасан зохицох шалгууруудтай нийцэх нийцэл, уялдаа холбоо

Бодлого	Бэлчээрийн менежмент (Бэлчээрийн даац, бэлчээр сэлгэлт)	Малын усан хангамж	Бэлчээр ийн мэдээлл ийн систем	Зорилтот хадлан, тэжээл бэлтгэл	Үүлдэр угсааг сайжруул алт	Сүргийн бүтэц	Цаг агаарт зориудаар нөлөөлөх
ХӨГЖЛИЙН БОДЛОГУУД							
Аймгийн хөгжлийн цогц бодлого 2008-2020		+		+	+	+	
Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2016-2020	+				+	+	
БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН БОДЛОГУУД							
Бэлчээрийн менежментийн хөтөлбөр, 2012-2023		+	+				
Цөлжилттэй тэмцэх дэд хөтөлбөр, 2012-2020	+		+		+		+
Байгаль орчны мастер төлөвлөгөө, 2012-2020	+	+	+		+	+	+

Мал аж ахуйн салбарын дасан зохицох шалгууруудтай нийцэх нийцэл, уялдаа холбоо

Бодлогын хүрээ	Дасан зохицох шалгууртай нийцэл
Хөгжлийн бодлого	1.5
Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлого 2008 – 2020	2
Говь-Алтай аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 2016 – 2020	1
Байгаль орчны бодлого	1.3
Аймгийн бэлчээрийн менежментийн хөтөлбөр 2012-2023	2
Аймгийн цөлжилтийг сааруулах дэд хөтөлбөр 2012 – 2020	1
Байгаль орчны мастер төлөвлөгөө 2012 – 2020	1

ТХЗ-д суурилсан орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих шалгуур үзүүлэлтүүд

Багц	Шалгуур үзүүлэлт	ТХЗ
Дасан зохицох (Adaptation) (Нийгмийн дасан зохицох, сэргэн хөгжих чадавх)	Амьжиргааны олон талт эх үүсвэрийг бий болгож, ядуурлыг бууруулах	ТХЗ 1
	Эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тогтолцоог бий болгох, иргэдийн эрүүл мэндийг дэмжих Урьдчилан сэргийлэх оношилгоо үйлчилгээний чанар, хүртээмж, нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг бууруулах; зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг бууруулах; халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхийг бэхжүүлэх	ТХЗ 3
	Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангах, ариун цэврийн байгууламж нэмэгдүүлж, усны зохистой хэрэглээг дэмжих	ТХЗ 6
	Зохистой хөдөлмөр эрхлэлт, ажлын байр. Мал эмнэлгийн үйлчилгээ, худалдаа, тээвэр, боловсруулалт, дэд бүтцийн чиглэлээр эдийн засгийн арга хэмжээнүүдийг авах	ТХЗ 8
	Байгалийн болон соёлын нөөцөд суурилсан байгальд ээлтэй, тогтвортой аялал жуулчлал	ТХЗ 8
(Байгалийн сэргэн хөгжих чадавх)	Бэлчээрийн зохистой менежмент, бэлчээрийн экосистемийн хамгаалал. Бэлчээрийг даацад тохируулан мал сүргийн бүтэц, үүлдэр угсааг сайжруулах, бэлчээрийг сэлгэн, хуваарьтай ашиглах, усжуулалтыг нэмэгдүүлж бэлчээрийн газар ашиглалтыг сайжруулах	ТХЗ 15
	Ойн тогтвортой менежмент. Ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, мод үржүүлэх, ойн түймэртэй тэмцэх арга хэмжээ	ТХЗ 15
	Цөлжилт, газрын доройтлыг сааруулах. Хөрсийг нөхөн сэргээх, мэрэгчээс хамгаалах арга технологи нэвтрүүлэх, олон салаа зам гаргахгүй байх,	ТХЗ 15

ТХЗ-д суурилсан орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих шалгуур үзүүлэлтүүд

Багц	Шалгуур үзүүлэлт	ТХЗ
Дасан зохицох (Adaptation) (Нийгмийн дасан зохицох, сэргэн хөгжих чадавх)	Амьжиргааны олон талт эх үүсвэрийг бий болгож, ядуурлыг бууруулах	ТХЗ 1
	Эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тогтолцоог бий болгох, иргэдийн эрүүл мэндийг дэмжих Урьдчилан сэргийлэх оношилгоо үйлчилгээний чанар, хүртээмж, нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг бууруулах; зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг бууруулах; халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхийг бэхжүүлэх	ТХЗ 3
	Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангах, ариун цэврийн байгууламж нэмэгдүүлж, усны зохистой хэрэглээг дэмжих	ТХЗ 6
	Зохистой хөдөлмөр эрхлэлт, ажлын байр. Мал эмнэлгийн үйлчилгээ, худалдаа, тээвэр, боловсруулалт, дэд бүтцийн чиглэлээр эдийн засгийн арга хэмжээнүүдийг авах	ТХЗ 8
	Байгалийн болон соёлын нөөцөд суурилсан байгальд ээлтэй, тогтвортой аялал жуулчлал	ТХЗ 8
(Байгалийн сэргэн хөгжих чадавх)	Бэлчээрийн зохистой менежмент, бэлчээрийн экосистемийн хамгаалал. Бэлчээрийг даацад тохируулан мал сүргийн бүтэц, үүлдэр угсааг сайжруулах, бэлчээрийг сэлгэн, хуваарьтай ашиглах, усжуулалтыг нэмэгдүүлж бэлчээрийн газар ашиглалтыг сайжруулах	ТХЗ 15
	Ойн тогтвортой менежмент. Ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, мод үржүүлэх, ойн түймэртэй тэмцэх арга хэмжээ	ТХЗ 15
	Цөлжилт, газрын доройтлыг сааруулах. Хөрсийг нөхөн сэргээх, мэрэгчээс хамгаалах арга технологи нэвтрүүлэх, олон салаа зам гаргахгүй байх,	ТХЗ 15

ТХЗ-д суурилсан орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих шалгуур үзүүлэлтүүд

Багц	Шалгуур үзүүлэлт	ТХЗ
Дасан зохицох (Adaptation) (Нийгмийн дасан зохицох, сэргэн хөгжих чадавх)	Амьжиргааны олон талт эх үүсвэрийг бий болгож, ядуурлыг бууруулах	ТХЗ 1
	Эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тогтолцоог бий болгох, иргэдийн эрүүл мэндийг дэмжих Урьдчилан сэргийлэх оношилгоо үйлчилгээний чанар, хүртээмж, нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг бууруулах; зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг бууруулах; халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхийг бэхжүүлэх	ТХЗ 3
	Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангах, ариун цэврийн байгууламж нэмэгдүүлж, усны зохистой хэрэглээг дэмжих	ТХЗ 6
	Зохистой хөдөлмөр эрхлэлт, ажлын байр. Мал эмнэлгийн үйлчилгээ, худалдаа, тээвэр, боловсруулалт, дэд бүтцийн чиглэлээр эдийн засгийн арга хэмжээнүүдийг авах	ТХЗ 8
	Байгалийн болон соёлын нөөцөд суурилсан байгальд ээлтэй, тогтвортой аялал жуулчлал	ТХЗ 8
(Байгалийн сэргэн хөгжих чадавх)	Бэлчээрийн зохистой менежмент, бэлчээрийн экосистемийн хамгаалал. Бэлчээрийг даацад тохируулан мал сүргийн бүтэц, үүлдэр угсааг сайжруулах, бэлчээрийг сэлгэн, хуваарьтай ашиглах, усжуулалтыг нэмэгдүүлж бэлчээрийн газар ашиглалтыг сайжруулах	ТХЗ 15
	Ойн тогтвортой менежмент. Ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, мод үржүүлэх, ойн түймэртэй тэмцэх арга хэмжээ	ТХЗ 15
	Цөлжилт, газрын доройтлыг сааруулах. Хөрсийг нөхөн сэргээх, мэрэгчээс хамгаалах арга технологи нэвтрүүлэх, олон салаа зам гаргахгүй байх,	ТХЗ 15